



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 6/36

Улаанбаатар хот

“Журам, албан тушаалын ангилал,
үндсэн цалингийн сүлжээ, жишиг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 108 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8.8.9, 8.8.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мэргэшсэн хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, ажлын гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албаны байцаагчийн ажлын гүйцэтгэл /KPI/-ийг үнэлэх, дүгнэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албаны байцаагчийн албан тушаалын ангилал, үндсэн цалингийн сүлжээ, жишиг”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Шинэчлэн батлагдсан журам, үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон 2024 оны ажлын гүйцэтгэлийн дүн, гурвалсан тайлангийн хурлын үнэлгээг тус тус үндэслэн үндсэн цалингийн дэвд өөрчлөлт орох ажилтнуудын хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын захирал /Э.Мөнхмарал/-д даалгасугай.

3.Хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт орсон ажилтнуудыг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу цалинжуулахыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Д.Даваадорж/-д зөвшөөрсүгэй.

4.Батлагдсан журмын дагуу ажилтнуудынхаа ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлэх, хянах, тэдгээрийн ур чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албаны дарга /Д.Цогтгэрэл/-д үүрэг болгосугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/327 тоот тушаалын 2 дугаар хавсралтын болон Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/327 тоот тушаалын хавсралтын Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албанд хамаарах хэсгүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.МӨНХТАМИР

"МИАТ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2025 оны 01-р сарын 29-ны өдрийн
5/26 тоот тушаалын 2-р хавсралт



**"МИАТ" ТӨХК-ИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЧАНАР, НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН АЛБАНЫ АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ /КР/-ИЙГ
ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар "МИАТ" ТӨХК /цаашид "Компани" гэх/-ийн Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын алба /цаашид "ААЧНАБА" гэх/-ны ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх болон гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгохтой холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Компанийн нислэг-үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, чанар баталгаажуулалт, нисэхийн аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой аудит, үзлэг шалгалт, хяналтын үүрэг гүйцэтгэж байгаа ААЧНАБА-ны ажилтнуудад энэхүү журам хамаарна.
- 1.3. Компанийн нислэг-үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, чанар баталгаажуулалт, нисэхийн аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой аудит хийдэггүй ААЧНАБА-ны ажилтнууд болон тус албаны даргын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгохтой холбоотой харилцаанд энэхүү журам хамаарахгүй.
- 1.4. ААЧНАБА-ны ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгохтой холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална.
 - 1.4.1. шударга байх;
 - 1.4.2. үнэлгээ ил тод, нээлттэй байх;
 - 1.4.3. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
 - 1.4.4. зөвхөн бодит гүйцэтгэл, үр дүнд үндэслэх.
- 1.5. Энэхүү журмын Хавсралт 1-ийн дагуу ААЧНАБА-ны ажилтны ур чадварын шалгуур үзүүлэлтийг тогтооно.

**ХОЁР. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭЛД
СУУРИЛСАН НЭМЭГДЭЛ ОЛГОХ**

- 2.1. ААЧНАБА-ны ажилтны ажлын гүйцэтгэлийг тус албаны дарга үнэлгээний хуудас /Хавсралт 2/-ны дагуу доорх шалгуураар 0-100 хүртэлх онооны системээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Нөхцөл, тайлбар	Аргачлал
1.	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлын гүйцэтгэл	50	"emiat.miat.com" дээр хөгжүүлсэн "E-Task" цэсэнд орсон ААЧНАБА-ны батлагдсан төлөвлөгөөний дагуу болон нэмэлтээр хийж гүйцэтгэсэн ажлуудын гүйцэтгэлээр үнэлнэ. 1. Төлөвлөсөн хугацаандаа хийсэн байдал (10 хүртэл оноо) 2. Бүх ажлыг хийсэн байдал (30 хүртэл оноо)	1.1. Нийт гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил ба төлөвлөсөн хугацаандаа бүрэн хийсэн ажлын харьцаагаар хувьчилж гаргана. 2.1. Нийт гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил ба бүрэн хийж гүйцэтгэсэн ажлын харьцаагаар хувьчилж гаргана.

			3. "E-task" дээр ажилласан байдал (5+5)	3.1. Нийт ажилтнуудын гүйцэтгэсэн ажлын дундаж ба тухайн ажилтны гүйцэтгэсэн ажлын харьцаагаар хувьчилж гаргана. /Албаны дундаж таскаас доош бол 0 оноо, дундаж бол 5 оноо, дунджаас 20 хувь дээш бол 10 оноо/
2.	Бүтээлч, идэвхи, санаачлагатай байдал	18	Дараах шалгуураар үнэлнэ. 1. Ажлын хэсэгт ажилласан байдал (5) 2. Шинэ санаачлага гаргаж хэрэгжүүлсэн байдал (5) 3. Ажил "Таск"-ын хүндрэл (5 хүртэл оноо) 4. Ажлын цаг ашиглалт (3)	1.1. Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг, эсхүл хэлтэс, нэгжийн хамтарсан болон ААЧНАБА-ны хэмжээнд ажлын хэсгийн зохион байгуулалтад орж тодорхой ажил үүрэг гүйцэтгэсэн бол 5 оноо өгнө. 2.1. Тухайн улиралд шинэ санаачлага гаргаж хэрэгжүүлэн зохих үр дүн гарсан тохиолдолд 5 оноо өгнө. 3.1. "E-task" дахь ажлуудын агуулга, цар хүрээ, хийгдэх ажилбаруудын хүндрэлтэй байдлаас шалтгаалж 1-5 оноо өгнө. 4.1. Тухайн ажилтны цаг ашиглалтыг ААЧНАБА-ны даргаас хянаж 0-3 оноо өгнө.
3.	Ур чадвар, мэргэшсэн байдал	20	Энэхүү журмын Хавсралт 1-д заасан ур чадварын үзүүлэлт тус бүрээр үнэлж оноо өгнө.	12 ур чадварын үзүүлэлтээс хангаагүй ур чадвар бүрээр 2 оноо хасагдана.
4.	Аудитын чанар, үр дүн	12	1. Аудитын чанар, илрүүлсэн үл тохирлын ноцтой байдал тоо (8 хүртэл) 2. Үл тохирлыг хугацаанд нь хаалгасан байдал (4 оноо)	"Actionlog" программаар тооцно.
5.	Авбал зохих нийт оноо	100		

2.2. Албаны байцаагч нарын тухайн улирлын дундаж үнэлгээ гарсны дараа харгалзах улиралд тооцож, нэг удаа дараах байдлаар гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн нэмэгдэл олгоно.

1. Эхний 10%:

- Тухайн улирлын дундаж үнэлгээний хамгийн өндөр оноотой 10%-д багтсан ажилтан тус бүрт нэг сарын үндсэн цалингийн 90%-тай тэнцэх;

2. Дараагийн 15% (11%-25%):

- Тухайн улирлын дундаж үнэлгээгээр эхний 10%-д багтаагүй ч 11%-иас 25% хүртэлх завсарт багтсан (хамгийн өндөр оноо бүхий 10% ажилтны дараагийн 15%) ажилтан тус бүрт нэг сарын үндсэн цалингийн 60%-тай тэнцэх;

3. Дараагийн 25% (26%-50%):

- Тухайн улирлын дундаж үнэлгээний 26%-иас 50% хүртэлх завсарт багтсан (хамгийн өндөр оноо бүхий 25% ажилтны дараагийн 25%) ажилтан тус бүрт нэг сарын үндсэн цалингийн 30%-тай тэнцэх.

Тайлбар хүснэгт:

№	Ангилал	Ажилтны тооны хувь	Олгох хувь /%/	Тайлбар
1	Топ 10%	10%	90%	Хамгийн өндөр оноо бүхий 10% ажилтан
2	Топ 11%-25%	15%	60%	Хамгийн өндөр оноо бүхий 10% ажилтны дараагийн 15% ажилтан
3	Топ 26%-50%	25%	30%	Хамгийн өндөр оноо бүхий 25% ажилтны дараагийн 25% ажилтан
	Нийт дүн	50%	-	Үр дүнгийн нэмэгдэл олгох ажилтны тоог бодоход бутархай тоо гарвал бүхэлчилж бодно.

- 2.3. Энэхүү журмын 2.2-т заасан ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 60-69 оноо авсан ажилтныг ажлын байран дахь шаардлагыг хангаж ажилласан гэж үзэх бөгөөд аливаа нэмэгдэл, цалингийн шатлал ахиулах үндэслэл болохгүй.
- 2.4. Тухайн ажилтны бүтэн жилийн үнэлгээний дундаж 80 буюу түүнээс дээш оноогоор үнэлэгдсэн тохиолдолд тус ажилтны үндсэн цалингийн дэвийг 1 шатаар ахиулах үндэслэл болно.
- 2.5. Сарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 59 буюу түүнээс доош оноо авсан ажилтныг үндсэн ажил, үүргээ хангалтгүй гүйцэтгэсэнд тооцож, ажлын гүйцэтгэлээ сайжруулах 3 сарын хугацаа олгоно. Хэрвээ уг хугацаанд ажлын гүйцэтгэлээ сайжруулаагүй тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 3.1. Ажилтан үнэлгээтэй холбоотой гомдлоо тухайн улирлын үнэлгээ гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор нэгжийн даргадаа гаргах эрхтэй бөгөөд нэгжийн даргын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ажлын 3 хоногт багтаан Захиргаа, хүний нөөцийн хэлтэст гомдол гаргах эрхтэй.
- 3.2. Энэхүү журамд заасан гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн нэмэгдэл олгох, үндсэн цалингийн шатлал ахиулах, сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрийг Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар албажуулна.
- 3.3. Энэхүү журмын 3.2 дахь хэсэгт заасан шийдвэрийг гаргуулах талаар ААЧНАБА-ны дарга холбогдох үндэслэл бүхий саналаа үнэлгээний хуудсын хамтаар Захиргаа, хүний нөөцийн хэлтэст ирүүлэх бөгөөд тус хэлтэс ирүүлсэн саналыг нягталж, үндэслэлтэй гэж үзвэл Компанийн Гүйцэтгэх захиралд танилцуулж тушаалаар албажуулж цалин хөлсний нягтлан бодогчид шилжүүлнэ.
- 3.4. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

---oOo---

"МИАТ" ТӨХК-ийн аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албаны ажилтны ажлын гүйцэтгэл /КРП/-ийг үнэлэх, дүгнэх журмын хавсралт 1



**ААЧНАБА-НЫ АЖИЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ,
УР ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Албан тушаалын ангилал	Ур чадварын шалгуур үзүүлэлт	Зэрэг
1	Байцаагч	- Сүүлийн 24 сар байцаагчаар, эсхүл салбарт үйл ажиллагааны чиглэлээр 10 жил тогтвор суурьшилтай ажилласан; - TOEIC 600-аас дээш оноотой байх; - IATA болон түүнтэй дүйцэхүйц эрх бүхий сургалтын байгууллагад Internal auditor сургалтанд хамрагдаж гэрчилгээжсэн байх; SMS, QMS, эсхүл түүнтэй дүйцэхүйц мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байх; - Аудитын багт IATA ангиллаар 2-оос доошгүй чиглэлээр орж ажилласан байх; - Олон улсын стандарт (IOSA, ISAGO, EASA, FAA гэх мэт)-уудаар дотоод аудит хийж тайлан дүгнэлт гаргах, илэрсэн үл тохирол, зөвлөмжийн учир шалтгааныг тогтоох чадвартай байх; Actionlog систем дээр ажиллаж reporting system болон үзлэг шалгалтаар илэрсэн аюул, эрсдэлийг үнэлж, зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах үйл ажиллагаанд хяналт тавих чадвартай байх, хэрэгжүүлсэн байдал; - Хариуцсан чиглэлээр олон улсын хэмжээнд гарч буй аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг судалж Safety, Security, Quality bulletin бэлтгэх чадвартай, туршлагатай байх, хэрэгжүүлсэн байдал; - Өөрийн хариуцсан чиглэлээр "Change management"-ийг хэрэгжүүлсэн байдал; - Заавар, журам боловсруулах, өөрчлөлт хийх чадвартай байх; - Албаны дарга болон ахлах байцаагчийн хяналттайгаар гадаадын холбогдох байгууллагуудтай харьцан ажиллах чадвартай байх, хэрэгжүүлсэн байдал; - Чанарын зааврын 4.2.2-д заасан шаардлагыг хангасан байх.	S3
2	Ахлах байцаагч/ Менежер	- Сүүлийн 60 сар байцаагчаар, эсхүл салбарт үйл ажиллагааны чиглэлээр 15 жил тогтвор суурьшилтай ажилласан байх; - Чанарын зааврын 4.2.3-д заасан шаардлагыг хангаж аудитын баг ахлах ур чадвартай байх; - TOEIC 700-аас дээш оноотой байх, эсхүл 10-аас дээш жил байцаагчаар ажилласан байх; - Аудитын багт IATA ангиллаар 3-аас доошгүй чиглэлээр орж ажилласан байх; - IATA болон түүнтэй дүйцэхүйц эрх бүхий сургалтын байгууллагад (SMS, QMS, SEMS гэх мэт) мэргэшүүлэх сургалтад сууж гэрчилгээжсэн байх; Actionlog систем дээр ажиллаж компанийн хэмжээнд цугларсан аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, дахин давтан гаргахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлсэн байдал;	S2

		7. Байгууллагын хэмжээнд гарч буй өөрчлөлтийн хүрээнд "Change management"-ийг хэрэгжүүлэх чадвартай байх, хэрэгжүүлсэн байдал; 8. Заавар, журмыг холбогдох хууль, дүрмийн нийцлийн дагуу хянах чадвартай байх, хэрэгжүүлсэн байдал; 9. Өөрийн хариуцсан чиглэлээр гаднын байгууллагатай бие даан харьцан ажиллах чадвартай байх, хэрэгжүүлсэн байдал; 10. EASA, TCO, CAAM, FAA гэх мэт удирдах газруудтай compliance чиглэлээр ажиллах чадвартай байх, хэрэгжүүлсэн байдал; 11. Байгууллагын хэмжээнд болон өөрийн хариуцсан чиглэлээр SPI дүгнэх, трэнд анализ хийдэг байх; 12. Байгууллагын хэмжээнд болон өөрийн хариуцсан чиглэлээр залруулах арга хэмжээ, сайжруулах арга хэмжээ хянах, үр дүнтэй байдал, гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт хийх чадвартай байх.	
--	--	---	--

---oOo---



"МОН" ТӨХК-ийн ААЧНАБ-ын байцаагчийн ажлын гүйцэтгэл /КРІ-ийг үнэлэх, үндсэн палигийн зэрэг, дэвийг тогтоох журмын хайсралт

ААЧНАБ-НЫ АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№	Нэрс	Done	Over due	In Progress	Over due/Done	Approved plan	Head of department	Individual	assigned tasks	overdue +overdone	On time accomplishment %	Task accomplishment %	Task KPI % - 60 оноо	Бүтээлч, идэвхи, санаачлагатай байдал-18 оноо	1. Ажлын хэсэгт ажилласан байдал (5) 2. Шинэ санаачлагаа гаргаж хэрэгжүүлсэн байдал (5) 3. Ажил Task-ын хүндрэл (5 хуртат оноо) 4. Ажлын цаг ашиглалт (3)	Ур чадварын шалгуур үзүүлэлт- 20 оноо (Хангаагүй шаардлага тус бүрд 2 оноо хасна)	Аудитын чанар, үр дүн-72 оноо	чанар- илрүүлсэн үр тохирлын ноцтой байдал тоо (8 хүртэл) 2. Үл тохирлыг хугацаанд нь хаалгасан байдал (4 оноо)	НИЙТ ОНОО =100
1																			
2																			
3																			
4																			
5																			
6																			

УНДГАЙН ХЭСЭГ: ААЧНАБ-НЫ ДАРГА